

2026.06.15 Газар эзэмшүүлэх тухай А/388

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 56 дугаар тогтоолоор баталсан сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу эзэмшил газраа нөхөх олговортойгоор солих хүсэлт гаргасан иргэн Х.Золбаярт (М389010683) 500 мкв газрыг хавсралтад дурдсан хэмжээ, байршил, хугацаа, зориулалтын дагуу эзэмшүүлсүгэй.

2.Энэ захирамж гаргасантай холбогдуулан Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/98 дугаар захирамжийн хавсралтын 4 дүгээр мөрийг хүчингүй болгосугай.

3.Эзэмшил газраа нөхөх олговортойгоор сольсон иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын даамал (Г.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.МӨНХБАЯР